



СОЁЛЫН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

**АРХИТЕКТУРЫН
ӨВИЙГ ХАДГАЛЖ
ХАМГААЛАХ БАРИМТ
БИЧИГ**

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ



**АРХИТЕКТУРЫН ӨВИЙГ ХАДГАЛЖ
ХАМГААЛАХ БАРИМТ БИЧИГ**

Улаанбаатар, 2020

АРХИТЕКТУРЫН ӨВИЙГ ХАДГАЛЖ ХАМГААЛАХ БАРИМТ БИЧИГ

Хянан тохиолдуулсан: З.Оюунбилэг (Ph.D)

Орчуулсан: Ц.Цолмон, З.Оюунбилэг, Д.Цэдмаа

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: А.Намуун

Хэвлэлийн газар: «Эгүлэн медиа эйжинси» ХХК

АРХИТЕКТУРЫН ӨВИЙГ ХАДГАЛЖ ХАМГААЛАХ БАРИМТ БИЧИГ

ГАРЧИГ

Өмнөх үг

1. Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил
гүйцэтгэх журам, 2004 8
2. Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хадгалж хамгаалах,
сэргээн засварлах олон улсын Харты, 1964 (*Д.Цэдмаа*) 13
3. Түүхэн дурсгалт модон бүтээцийг
хадгалах зарчим, 1999 (*Ц.Цолмон*) 18
4. Архитектурын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах
болон дүн шилжингээ хийх зарчим, 2003 (*З.Оюунбилэг*) 23
5. Буррагийн Харты, 2013 (*Ц.Цолмон*) 28

DOCUMENTS FOR CONSERVATION OF ARCHITECTURAL HERITAGE

CONTENTS

1. Rule for the restoration of historical and cultural monuments, 2004	8
2. International Charter for the Conservation and Restoration of Monuments and Sites-Venice Charter, 1964	13
3. Principles for the Preservation of Historic Timber Structures, 1999	18
4. Principles of conservation, restoration and analysis of architectural heritage, 2003	23
5. The Burra Charter, 2013	28

ӨМНӨХ ҮГ

Анх 1931 онд Афин хотод болсон түүхэн хөшөө дурсгалын архитектор, мэргэжилтний Олон улсын анхдугаар их хурлаар долоон зүйл бүхий Тунхаг бичиг буюу “Түүхэн хөшөө дурсгалыг сэргээн засварлах Афины Харти” (Athens Charter for the Restoration of Historic Monuments, 1931)-ийг баталсан билээ. Энэхүү баримт бичиг нь анх удаа түүхэн дурсгалыг сэргээн засварлах үндсэн зарчмыг тодорхойлж, олон улсын хэмжээнд соёлын өвийн тухай ойлголтыг нэвтрүүлж, түүнийг хамгаалах, сэргээн засварлахад олон улсын хэмжээний өргөн цар хүрээтэй хөдөлгөөний өрнүүлэн хөгжүүлэхэд буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO, 1945), Олон улсын музейн зөвлөл (ICOM, 1946), Соёлын өвийг хадгалах, сэргээн засварлах ажлын судалгааны төв (ICROM, 1956) зэрэг олон улсын байгууллага үүсэх эхийг тавьж, хувь нэмрээ оруулсан гэж үздэг.

Соёлын дурсгалыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах ажилд олон улсын хэмжээнд улам нарийн төвөгтэй олон асуудлууд тулгарч, мэдлэг, судалгааг нэмэгдүүлэх, хадгалах, сэргээн засварлах зарчмыг нарийвчлан судалж, түүнд хамруулах хүрээг өргөтгөх зорилгоор дээрх “Афины Харти”-г дахин судлах цаг болсон хэмээн үзэж 1964 онд Олон улсын түүхэн хөшөө дурсгалын архитектор, мэргэжилтний II Конгрессыг Венец хотноо хуралдуулж “Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах олон улсын дүрэм” (International Charter for the Conservation and Restoration of Monuments and Sites-Venice Charter, 1964)-ийг хэлэлцэж гаргасныг 1965 онд ICOMOS баталсан юм. Энэхүү дүрмийг хэрэгжүүлэх зорилгоор 1965 онд ЮНЕСКО-гийн дэргэд Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хамгаалах Олон улсын зөвлөл (ICOMOS) байгуулагдсан болно.

ICOMOS нь дэлхийн өнцөг булан бүрд байгаа хөшөө дурсгал, дурсгалт газрын хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус олон улсын байгууллага бөгөөд түүний салбар хороо нь улс бүхэнд ажиллаж байна. Түүнээс гадна ICOMOS нь ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хороонд Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэхээр санал болгож буй соёлын үнэт зүйлсийн шинж чанарыг үнэлэх, харьцуулсан судалгаа, техникийн судалгаа болон дурсгал газрын хадгалалтын байдлын тайланг гаргаж өгдөг юм. ICOMOS-оос хөшөө дурсгал, дурсгалт газрыг хамгаалах, хадгалах, сэргээн засварлах талаар олон улсын хэмжээнд

болон бүс нутгийн хэмжээнд мөрдөх дүрэм, журам, зарчим зэргийг боловсруулан мөрдүүлдэг.

Монгол Улс 1972 оны “Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах олон улсын конвенци”-д 1990 онд нэгдэн орсон орны хувьд ICOMOS-оос соёлын өв тухайлбал, хөшөө дурсгал, архитектурын болон археологийн өв, модон барилга, түүхэн хот зэргийг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах талаар батлан гаргасан олон улсын дүрэм, зарчмыг үйл ажиллагаандаа даган мөрдөх үүрэгтэй билээ. Тиймээс бид эхний ээлжид ICOMOS-ийн баталсан “Хөшөө дурсгал, дурсгалт газрын хадгалж хамгаалах, сэргээн засварлах дүрэм”, “Архитектурын өвийг хадгалж хамгаалах, сэргэн засварлах болон дүн шинжилгээ хийх зарчим”, соёлын өвийн менежментийн онол, практик ойлголтыг хөгжүүлэх зорилготой “Буррагийн дүрэм”-ийг орчуулж, хөшөө дурсгал, архитектурын өв, түүхэн дурсгалт барилгыг хадгалах, хамгаалах, сэргээн засварлахад гар бие оролцож буй хэн бүхэнд тухайлбал, архитектор, инженер, сэргээн засварлагч, техникийн ажилтан, археологич, урлаг судлаач, түүхч, судлаач Та бүхний ажлын хэрэгцээнд зориулан орчуулан хэвлэж өргөн барьж байна. Түүнчлэн 2004 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Дэд бүтцийн сайдын хамтарсан тушаалаар баталсан “Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журам”-ын хамт хэвлэсэн болно.

Дашрамд дурдахад 2019 оноос эхлэн Соёлын өвийн Үндэсний төвийн дэргэд “Архитектурын өвийг хадгалж хамгаалах, сэргэн засварлах болон дүн шинжилгээ хийх Шинжээчийн зөвлөл” байгуулагдан, Дэлхийн өвд бүртгэгдсэн Монгол улсын соёлын өв болон улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад буй түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтад үзлэг хяналт, дүн шинжилгээ хийх, зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах зэрэг ажлыг гүйцэтгэж байна.

Соёлын өвөө хайрлан хадгалж хамгаалан, сэргээн засварлаж хойч үедээ өвлүүлэн үлдээх эрхэм үүргийг хүлээсэн Та бүхний ажил үйлс дэлгэрэх болтугай.

Монгол Улсын Зөвлөх архитектор,
Доктор, З.Оюунбилэг

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, ДЭД БҮТЦИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2004 оны 5-р сарын 24-ний өдөр Дугаар 183/111 Улаанбаатар хот

Журам батлах тухай

“Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 21.1 дүгээр заалт, “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах Үндэсний хөтөлбөр”- ийг чанартай хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Соёл, урлагийн бодлого, зохицуулалтын газар (Л.Эрдэнэчимэг), Соёл, урлагийн сан (Н.Бямбажав), Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар (Б.Бямбажав) нарт тус тус даалгасугай.

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

ДЭД БҮТЦИЙН САЙД

А.ЦАНЖИД

Б.ЖИГЖИД

*Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд,
Дэд бүтцийн сайдын 2004 оны 183/111
тоот хамтарсан тушаалын хавсралт*

ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛЫГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох эртний хот суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз болон уран барилгын цогцолбор, сүм дуган, хийд, гудамж талбай, байшин барилга зэрэг уран барилгын дурсгалыг сэргээн засварлах зураг төсөл боловсруулах болон сэргээн засварлах ажил гүйцэтгэхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах зураг төсөл боловсруулах болон сэргээн засварлах ажлыг гүйцэтгэхдээ “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”, “Барилгын тухай хууль”, “Архивын тухай хууль”, “Зураг төсөл, хайгуул судалгааны ажилд улсын экспертиз хийх дүрэм” БНБД11-02-97, “Зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, батлах дүрэм” БНБД11-01-98, “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх дүрэм” БНБД 11-04-99, “Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдах барилга, байгууламжийн зураг төслийг гадаадын байгууллагаар гүйцэтгүүлэх журам” БНБД11-03-02, “Зураг төслийн ажлын үнэ” БД81-16-00, “Барилга байгууламжийг ашиглалт оруулах журам” зэргийг тус тус мөрдлөг болгоно.

1.3. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, олон улсын байгууллага болон гадаадын байгууллага энэхүү журмыг нэгэн адил мөрдөнө.

1.4. Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах зураг төсөл боловсруулах болон сэргээн засварлах ажил гүйцэтгэхэд барилгын ажлын ерөнхий шаардлагыг тавих боловч нь зарим онцлогийг энэхүү журамд тусгалаа.

Хоёр. Сэргээн засварлах зураг төсөл боловсруулах ажлын зохион байгуулалт

2.1. Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил, сэргээн засварлах зураг төслийг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж гүйцэтгэнэ.

2.2. Түүх, соёлын дурсгалын сэргээн засварлах зураг төслийг газар дээр нь хийсэн хэмжилт судалгаа болон архивын судалгааг үндэслэн гүйцэтгэнэ.

2.3. Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах зураг төсөлд улсын экспертизийн дүгнэлт хийлгэсэн байна.

Гурав. Сэргээн засварлах зураг төслийн бүрдэл, түүнд тавих шаардлага

3.1. Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажлын зураг нь дараах үндсэн бүрдэлтэй байна. Үүнд:

- 3.1.1. дурсгалын түүх-архивын судалгаа
- 3.1.2. дурсгалын эвдрэл гэмтлийн тодорхойлолт
- 3.1.3. гэрэл зургийн цомог
- 3.1.4. хэмжилтийн зураг
- 3.1.5. сэргээн засварлах ажлын зураг
- 3.1.6. өнгө будгийн зураг
- 3.1.7. сэргээн засварлах ажлын төсөв

3.2. Түүх, соёлын дурсгалын түүх-архивын судалгааг номын сан, музей, архив зэрэг газраас судалсан уг дурсгалтай холбоотой түүхийн материалууд, гар зураг, баримтат гэрэл зураг, гар бичмэл болон тухайн дурсгалыг сайн мэдэх хүмүүсийн яриа, дурдатгал зэрэг аман судалгаагаас бүрдэнэ.

3.3. Түүх, соёлын дурсгалт барилгын эвдрэл гэмтлийн тодорхойлолтыг бичихдээ ерөнхий гэмтлийн шинж байдал (хагарал, суулт г.м)-ыг сууринаас дээвэр хүртэл тодорхойлон бичнэ. Хийц, хэсэглэл (хана, багана, цонх, хаалга, архитектурын чимэглэл г.м)-ийн эвдрэл гэмтлийн тус бүрд нь тодорхойлон бичнэ.

3.4. Дурсгалын орчны байдал, ерөнхий байдал, хэсэглэлийн (протоколын) хар, цагаан болон өнгөт гэрэл зургаас гэрэл зургийн цомог бүрдэнэ. Гэрэл зураг нь уран сайхны зураг, баримтат ба протоколын зураг, өнгөт зураг, өнгөт слайд гэсэн 4 төрөл байна. Протоколын гэрэл зурагт эвдрэл гэмтэл, сэргээн засварлах ажлын эхлэл, явц, төгсгөлийн үеүдийг үзүүлнэ.

3.5. Дурсгалын хэсэглэл, малтлага, ховхлолт болон эвдэрсэн хэсгийн хэмжээг тодруулахын тулд гэрэл зураг авах үедээ сантиметр, дециметрийн хуваарьтай шугам, модыг хэрэглэнэ.

3.6. Дурсгалын хэмжилтийн зураг нь газар дээр нь хийсэн судалгаа болох барилгын зураглал болон малталт хийсэн зургийг тодорхой масштабд оруулж зурсан зургаас бүрдэнэ. Хэмжилтийн зурагт эвдрэл, гэмтлийг тодорхой үзүүлнэ.

3.7. Дурсгалт барилгын хэмжилтийн болон ажлын зургийн тохиромжтой масштаб нь нүүр тал, ар тал, хажуу тал, огтлол, байгуулалтыг 1:50, 1:25, 1:20, хийц, хэсэглэлийг 1:10, 1:5, 1:2, зарим шаардлагатай зураглалыг байгаа хэмжээгээр нь буюу 1:1 масштабаар тус тус зурна.

3.8. Ямпай, сүүдрэвч, суварга, хүндэтгэлийн хаалга гэх мэт архитектурын жижиг хэлбэрийн дурсгалын хэмжилтийн болон ажлын зургийг 1:25, 1:20, 1:10, 1:5 масштабаар, хэрэм зэрэг урт барилга байгууламжийн хэмжилтийн болон ажлын зургийг 1:100, 1:200 масштабаар зурах бөгөөд зарим чухал хэсэглэл, огтлолыг 1:50 масштабаар тус тус зурна.

3.9. Сэргээн засварлах ажлын зураг нь дурсгалын нүүр, ар, хоёр хажуу тал, хөндлөн, дагуу огтлол, давхрын байгуулалтууд, суурь болон дээврийн байгуулалт, модон хийцийн зураглалууд эсгүүрийн хамт, цонх, хаалга, дээврийн чимэглэл, хэсэглэлийн зургуудаас бүрдэнэ.

3.10. Өнгө будгийн ажлын зургийг газар дээр нь хийсэн өнгөний судалгааг үндэслэн шивээсийн хамт 1:1 масштабаар гүйцэтгэнэ.

3.11. Сэргээн засварлах ажлын зургийг үндэслэн сэргээн засварлах ажлын төсвийг зохионо.

Дөрөв. Сэргээн засварлах ажилд тавих шаардлага

4.1. Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлахдаа олон улсын хэмжээнд мөрдөж буй Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах тухай олон улсын Хартийн дагуу анхных төрх байдлаар сэргээн засварлана.

4.2. Дурсгалыг сэргээн засварлах явцад шаардлага хангах хийц, хэсэглэл, чимэглэлийг үлдээх буюу сэлбэн хэрэглэнэ.

4.3. Сэргээн засварлах ажлыг гүйцэтгэхдээ 15%-иас ихгүй чийгтэй модон материалыг хэрэглэнэ.

4.4. Сэргээн засварлах зурагт заасны дагуу хэмжээ, эсгүүрээр модон материал болон вааран эдлэлийг нэг жилийн өмнө бэлтгэсэн байна.

4.5. Сэргээн засварлах ажилд уламжлалт арга барил болон байгалийн гаралтай будгийг хэрэглэнэ.

4.6. Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажлын явцад “Барилгын тухай хууль”-ийн 18 дугаар зүйл, “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх дүрэм” БН6Д11-04-99-ийн дагуу хяналт тавина.

4.7. Сэргээн засварлах ажлыг гүйцэтгэгч нь сэргээн засварлахын өмнөх, ажлын эхлэл, явц, сэргээн засварласны дараах гэрэл зургийг хавсаргасан ажлын тайланг бичиж захиалагчид хүлээлгэн өгнө.

4.8. Захиалагч нь сэргээн засварлах ажлын товч тайланг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд өгнө.

4.9. Сэргээн засварлах ажил дууссаны дараа “Барилга байгууламжийг ашиглалт оруулах журам”-ын дагуу улсын комисс хүлээн авна.

Тав. Бусад зүйл

5.1. Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлуулах захиалагч байгууллага буюу соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрээний үндсэн дээр сэргээн засварлах зураг, төсвийг хийлгэж гүйцэтгэгч байгууллагад өгнө.

5.2. Захиалагчийн хүсэлтээр гэрэл, цахилгаан, аянгын хамгаалалт, дохиоллын системийн зургийг нэмж хийж хавсаргаж болно.

5.3. Сэргээн засварлах ажлын зургийг (6 бүрдэл бүхий) 3 хувь хувилж эх хувийг Үндэсний төв архивд, нөгөө хоёр хувийг захиалагч болон гүйцэтгэгч байгууллагад хүлээлгэн өгнө.

--- о О о ---

ХӨШӨӨ ДУРСГАЛ, ДУРСГАЛТ ГАЗРЫГ ХАДГАЛЖ ХАМГААЛАХ, СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ОЛОН УЛСЫН ХАРТИ

Түүхэн дурсгалт барилгын архитектор, мэргэжилтнүүдийн Олон улсын II конгрессоос батлав. Итали улс, Венец хот. 1964 он (ICOMOS 1965 онд баталсан)

Түүхэн хөшөө дурсгал нь өнгөрсөн үеийн элч болж эртний өв уламжлалын амьд гэрчээр бидний үед хүрч ирсэн юм. Хүмүүс хүн төрөлхтний үнэт зүйлийн нэгдлийг улам бүр ухаарч, эртний хөшөө дурсгалыг бүх нийтийн өв гэж ойлгох боллоо. Иймд түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах нь хойч үеийнхээ өмнө хүлээх үүрэг хэмээн үзэх үзэл болжээ. Бидний үүрэг бол тэднийг бүрэн эхээр нь хойч үедээ өвлөн хүлээлгэн өгөх явдал юм.

Эртний барилгыг хадгалах, сэргээн засварлах ажлын үндсэн зарчмын мөн чанар нь орон бүр өөрийн соёл, өв уламжлалын онцлогоо олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээний хүрээнд зохицуулан хэрэгжүүлэхэд оршино.

Эдгээр үндсэн зарчмуудыг анх 1931 оны Афины Харти тодорхойлсон бөгөөд энэ үеэс эхлэн олон улсын хамтын ажиллагаа эрчимтэй хөгжсөний үр дүнд олон улсын хамтын ажиллагааг дэмжин уриалсан үндэсний баримт бичгүүд, Олон Улсын Музейн Зөвлөл (ICOM), ЮНЕСКО-гийн үйл ажиллагаа бий болж, энэ байгууллагын хүрээнд Соёлын өвийг хадгалалт, сэргээн засварлалтыг судлах Олон улсын төв байгуулагдсан юм. Энэхүү баримт бичгийг мөрдөх явцад олон бэрхшээл, нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэх, цаг үеийн байдлаас шалтгаалан баримт бичгийн ач холбогдлыг тодотгох шаардлага урган гарчээ.

Иймээс 1964 оны 5 дугаар сарын 25-31-нд Венец хотноо хуралдсан түүхэн дурсгалт барилгын архитектор, мэргэжилтнүүдийн Олон улсын II Конгрессоос доорх баримт бичгийг баталсан байна.

ТОДОРХОЙЛОЛТ

Нэгдүгээр зүйл

Түүхэн хөшөө дурсгалын тухай ойлголтод тухайлсан ганц нэг барилга байгууламж төдийгүй аливаа соёл иргэншлийн ул мөр, түүхэн болон тэмдэглэлт үйл явдалтай шууд холбоотой хот суурин, орон нутгийн асуудал багтдаг. Түүнчлэн урлагийн шилдэг бүтээлүүд орохоос

гадна цаг хугацаа өнгөрөх тутам соёлын үнэ цэнэ нь улам бүр нэмэгдэж байдаг өнгөрсөн үеийн эд өлгийн зүйлүүд ч хамрагдана.

Хоёрдугаар зүйл

Архитектурыг өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах ажилд уг дурсгалыг авран хамгаалах, судлахад үр нөлөө болохуйц шинжлэх ухаан, техникийн бүхий л ололт амжилт, нөөц боломжийг ашиглах шаардлагатай.

Гуравдугаар зүйл

Хөшөө дурсгалыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах ажил нь тэдгээрийг зөвхөн урлагийн бүтээлийн хувьд бус түүхийн гэрч баримтын хувьд авран хамгаалахад чиглэгдэнэ.

ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ (CONSERVATION)

Дөрөвдүгээр зүйл

Хөшөө дурсгалыг хадгалж хамгаалах ажлын агуулга нь түүний байгаа байдлыг өөрчлөн хувиргалгүйгээр бэхжүүлэн хамгаалахад оршдог.

Тавдугаар зүйл

Хэрэв хөшөө дурсгал нь нийтийн хэрэгцээнд ашиглагдаж байгаа бол тэдгээрийг бэхжүүлэн хамгаалах ажлыг эн тэргүүнд хийх шаардлагатай. Энэ нөхцөлд уг барилгын төлөвлөлт, засал чимэглэлийг өөрчлөхөөс аль болох зайлсхийх ёстой бөгөөд гагцхүү барилгын зориулалтыг өөрчилж болох юм.

Зургаадугаар зүйл

Хөшөө дурсгалыг хадгалж хамгаалах ажлыг явуулахдаа тэдгээрийн орчин тойрны байдлыг анхаарах хэрэгтэй. Хэрэв уламжлалт орчин нь хэвээр байгаа бол түүнийг хадгалж үлдээвэл зохино. Өнгө ба массын харьцааг өөрчлөхүйц шинэ барилга байгууламж, өөрчлөлт, шинэчлэлтийг уг орчинд байлгаж болохгүй.

Долоодугаар зүйл

Хөшөө дурсгал болон түүний оршин буй газар нь түүхийн тодорхой үйл явдлын ул мөрийг өөртөө агуулсан байдаг. Үндэсний болон олон улсын хэмжээний зайлшгүй онцгой зорилго, сонирхлоос бусад тохиолдолд хөшөө дурсгалыг бүхэлд нь юм уу, хэсэгчлэн өөрчилж, холилдуулж болохгүй.

Наймдугаар зүйл

Хөшөө дурсгалын салшгүй хэсэг болох уран баримал, уран зураг, чимэглэлийг зөвхөн хадгалж хамгаалах зайлшгүй шаардлагын үндсэн дээр эх биетээс нь салгаж болно.

СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ (RESTORATION)

Есдүгээр зүйл

Сэргээн засварлалт нь өндөр түвшний мэргэжлийн үйл ажиллагаа юм. Энэ ажлын зорилго нь барилгын хуучин эх материалд тулгуурлан түүний уламжлан ирсэн гоо сайхны болон түүхийн үнэт чанарыг тогтооход оршино. Зайлшгүй, онцгой, ижил төрлийн ямар ч нэмэлт сэргээн засварлалт нь уг дурсгалын архитектурын зохиомжоос ялгагдах ёстой бөгөөд энэ асуудал хаана бүрхэгдэнэ тэнд сэргээн засварлах үйл ажиллагааг зогсооно. Сэргээн засварлалт нь хөшөө дурсгалын археологийн болон түүхийн судалгааны дүгнэлтээр баяжиж, түүнд тулгуурлаж байх ёстой.

Аравдугаар зүйл

Сэргээн засварлах уламжлалт технологи нь сэргээн засварлах ажлын явцад тохирохгүй байгаа нөхцөлд үр дүн нь шинжлэх ухааны үзүүлэлт, практикаар нотлогдсон орчин үеийн технологийг ашиглаж болно.

Арван нэгдүгээр зүйл

Барилгын хэв маягийн нэгдлийг сэргээх нь сэргээн засварлалтын үндсэн шинж учраас түүхийн өөр өөр үед тухайн барилгад нэмэлт болон шингэсэн архитектурын ололтыг хүндэтгэх ёстой. Барилга нь түүхийн өөр өөр үеийн нэмэгдэл давхаргуудтай, үндсэн хэсэг нь хөндийрч хэврэгшсэн, гэтэл ил байгаа материал нь түүх, археологийн ба гоо сайхны үлэмж ач холбогдолтой бол нүдэнд үл харагдах хэсгийг өнгөн хэсгийн үзэмж төрхийг алдагдуулалгүйгээр өөрчилж болно. Барилгын энэ хэсгийн элементийг хөндөж хөдөлгөх, устгаж авч хаях тухай асуудлыг тухайн ажлыг гүйцэтгэгч байгууллагын удирдлага шийдвэрлэхгүй.

Арван хоёрдугаар зүйл

Барилгын устаж үгүй болсон хэсгийг орлуулах зүйл нь эх биетэйгээ зохицсон байхын зэрэгцээ эх биеэсээ ялгагдахуйц байх ёстой. Учир нь

сэргээн засварлалтын ажил нь барилгын уран сайхны болон түүхийн дахин давтагдашгүй шинжийг халхлах ёсгүй.

Арван гуравдугаар зүйл

Сэргээн засварлалтын явцад барилгын сонирхол татах хэсэг, хуучин байршил, орчин тойронтойгоо холбогдох зохиомж зэрэг нь өөрчлөгдөн анхны төрх нь бүдгэрсэн тохиолдолд нэмэлт сэргээн засварлалт хийх шаардлагагүй зөвхөн бэхжүүлэн үлдээнэ.

ТҮҮХИЙН ДУРСГАЛТ ГАЗАР (HISTORIC SITES)

Арван дөрөвдүгээр зүйл

Түүхэн дурсгалт газрууд нь бүрэн бүтэн байдал, цэвэрлэгээ, хамгаалалтын зохих түвшинг хангасан тусгай халамж шаарддаг объект юм. Эдгээр газруудад хийгдэх хадгалалт хамгаалалт болон сэргээн засварлалтын ажил нь дээр дурдсан зарчмаар явагдана.

МАЛТЛАГА СУДАЛГАА (EXCAVATIONS)

Арван тавдугаар зүйл

1956 онд ЮНЕСКО-гоос баталсан “Археологийн малтлага явуулах олон улсын зарчмуудыг тодорхойлсон зөвлөмж” баримт бичигт тусгагдсан шинжлэх ухааны стандарт зарчмуудын дагуу малтлага судалгаа явуулна.

Булш, балгас болон түүний олдворууд нь архитектурын элементийн нэгэн адил хамгаалагдах бөгөөд тэдгээрийг байнга бэхжүүлж байхын тулд зохих журмын дагуу хэмжилт хийсэн байх ёстой. Түүнчлэн утга агуулгыг нь өөрчлөлгүйгээр булшны байгууламж, чимэглэл нь ойлгомжтой, цэвэр сайхан байх бүх талын арга хэмжээг авч байх шаардлагатай.

Шинэчлэн өөрчлөх ажлыг урьдчилан туршилт хийлгүйгээр гүйцэтгэхийг эрс хориглоно. Зөвхөн анастилоз (anastylosis) буюу энд тэнд тарсан тухайн хөшөө дурсгалд шууд хамаарах хэсгүүдийг эргүүлэн байрлуулахыг зөвшөөрнө. Тарсан хэсгүүдийг дахин холбоход ашиглах материал нь эх биетэд орсон материалаас заавал ялгагдаж байх шаардлагатай бөгөөд орох хэмжээ нь аль болох бага байх нь зохимжтой.

БАРИМТ МАТЕРИАЛ, ХЭВЛЭЛ (PUBLICATION)

Арванзургаадугаар зүйл

Хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, малтлага судалгааны ажлыг зохион байгуулахдаа зураг, гэрэл зураг, судалгааны материалаар баяжуулсан дүн шинжилгээ бүхий тайланг бичиж хадгална.

Баримт бичигт цэвэрлэх, бэхжүүлэх, өөрчлөн байрлуулах, нэгтгэн холбох зэрэг сэргээн засварлалтын явцад гүйцэтгэсэн ажлын бүх үе шатыг дэлгэрэнгүй тусгахаас гадна дурсгалт барилгын техникийн болон дүрслэлийн байдлыг дэлгэрэнгүй бичнэ. Эдгээр баримт бичиг нь байгууллага, газруудын архивд хадгалагдаж судлаачдын хүртээл болж байна.

--- о О о ---

МОДОН БАЙГУУЛАМЖИЙГ ХАДГАЛАХ ЗАРЧИМ

ICOMOS-ийн 12 дугаар Ерөнхий Ассамблейн хурлаар батлав.

Мексик улс. 1999 он.

Энэхүү баримт бичгийн зорилго нь түүхэн модон байгууламжийн соёлын ач холбогдлыг нь харгалзан хадгалах энгийн, бүх нийтээр ашиглаж болохуйц зарчим, туршлагыг тодорхойлоход оршино. Түүхэн модон байгууламжид түүхэн газар, соёлын хувьд ач холбогдолтой бүх төрлийн барилга эсвэл бүхэлдээ болон хэсэгчлэн модоор баригдсан байгууламжийг хамруулдаг.

Түүхэн модон байгууламжийг хадгалах гол зорилго ба түүнд хамаарах зарчим:

- Дэлхийн соёлын өвийн нэг хэсэг болох бүх үеийн модон байгууламжийн ач холбогдлыг таньж хүлээн зөвшөөрөх;

- Түүхэн модон байгууламжийн олон янз байдлыг харгалзан үзэх;

- Тэдгээрийг барихад ашиглагдсан модны төрөл зүйл, чанарыг харгалзан үзэх;

- Чийгийн хэлбэлзэл, гэрэл, мөөгөнцөр, хорхой шавьжийн нөлөө, хуучирч элэгдэх, гал түймэр болон бусад гамшгаас үүдэлтэй байгаль орчны болон цаг уурын янз бүрийн нөхцөлд материалын ялзрал, доройтлын улмаас модны бүтэц бүхэлдээ болон хэсэгчлэн өмхөрч муудах зэрэг бүхий л асуудлыг танин мэдэх;

- Байгууллагын техник, технологи, уламжлалт ур хийцийн талаарх мэдлэг болон ур дүйн алдааг буруугаар хэрэглэх, түүхэн модон байгууламжийн ховордлын өсөлтийг танин мэдэх;

- Модон материалын хэврэг байдал, буруу ашиглалт, байгууламжийн хийц, технологитой холбоотой уламжлалт мэдлэг, туршлага үгүй болсноос үүдэлтэй модон байгууламжийн тоо, хэмжээ буурах;

- Эдгээр өвийн нөөцийг хадгалахад олон төрлийн арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатайг харгалзан үзэх;

- Венецийн Харти, Буррагийн Харти болон UNISCO, ICOMOS холбогдох баримт бичгийг анхаарч, эдгээр ерөнхий зарчмын түүхэн модон байгууламжийн хадгалалтад ашиглахыг эрэлхийлж дараах зөвлөмжийг гаргав.

ХЯНАЛТ, БҮРТГЭЛ, БАРИМТЖУУЛАЛТ

1. Венецийн Хартийн 16 дугаар зүйл болон ICOMOS -ийн “Хөшөө дурсгал, дурсгалт уран барилга болон дурсгалт газрыг бүртгэх” зарчимд

заасны дагуу хадгалалтын аливаа үйл ажиллагааг эхлэхийн өмнө тухайн бүтцийн нөхцөл байдал болон бүрэлдэхүүн хэсгүүд, засварын ажилд хэрэглэсэн материалыг нарийвчлан бүртгэж, баримтжуулна.

Түүхэн модон байгууламжийн бүтцээс хасагдсан хэсэг эсвэл нөөц материалын шинж чанарыг харуулсан дээж, уламжлалт ур чадвар болон технологид холбогдох бүхий л мэдээллийг цуглуулж, каталогжуулж, найдвартай хадгалах, мөн нээлттэй ашиглах нөхцлөөр хангах. Хадгалалтын үйл ажиллагаанд ашиглагдах болсон материал болон арга зүйн онцлогийг мөн баримтжуулах хэрэгтэй.

2. Хадгалалтын аливаа үйл ажиллагааг эхлэхээс өмнө тухайн модон байгууламжийн бүтцийн нөхцөл байдал, эвдрэлийг нарийвчлан оношилж шинжлэх хэрэгтэй. Оношилгоог баримтат нотолгоо, бодит хяналт шинжилгээ, шаардлагатай тохиолдолд бодит байдлын хэмжилт болон гэмтэл учруулахгүй туршилтын аргад тулгуурлан хийнэ. Энэ тохиолдолд бага зэргийн үйл ажиллагаа болон яаралтай хэрэгжүүлэх арга хэмжээнээс сэргийлэх шаардлагагүй.

АЖИГЛАЛТ БОЛОН ЗАСВАРЛАЛТ

3. Тогтмол хяналт, засвар үйлчилгээг уялдаа холбоотой хийх стратеги түүхэн модон байгууламж болон тэдгээрийн соёлын ач холбогдлыг хадгалахад нэн чухал юм.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

4. Хадгалалтын гол зорилго нь соёлын өвийн түүхэн эх байдал болон бүрэн бүтэн байдлыг хэвээр хадгалах юм. Хадгалалтын үйл ажиллагаа бүр бодит судалгаа болон үнэлгээнд суурилж хийгдэх ёстой. Асуудлыг гоо зүй, түүхэн үнэт зүйл, тухайн түүхэн бүтэц эсвэл дурсгалт газрын бодит бүрэн бүтэн байдлын холбогдох нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж, эдгээрийн дагуу шийдвэрлэх шаардлагатай.

5. Дараах хадгалалтын үйл ажиллагааг санал болгоно:

- a) уламжлалыг дагах;
- b) хоёр талт болгох, техникийн хувьд боломжтой;
- c) шаардлагатай хадгалалтын үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;
- d) хожим тухайн модон байгууламжид хамаарах баримт бичигт

саадгүй нэвтрэх нөхцлөөр хангах.

6. Түүхэн модон байгууламжид хадгалалтын үйл ажиллагааг явуулахдаа түүний бүтэц, хийцэд хамгийн бага нөлөөлөхийг чухалчилдаг. Зарим нөхцөл байдалд, хамгийн бага хадгалалтын үйл ажиллагаа гэдэг нь тухайн түүхэн модон байгууламжийг засварлах ажиллагааг явуулахын тулд түүнийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн буулгаж, дахин угсрахыг хэлдэг.

7. Хадгалалт, засварын үйл ажиллагааг явуулахдаа түүхэн модон байгууламжийн бүхий л материал, бүтцийн хэсгүүд, дүүргэлтийн хавтан, дээвэр, шал, хаалга, цонх гээд бүх хэсгийг нэг цул гэж үзэж бүгдийг нь анхаарах хэрэгтэй. Одоо байгаа материалыг аль болох хадгалахыг энэхүү зарчимд чухалчилдаг. Хадгалалтын үйл ажиллагаанд тухайн байгууламжийн гадна засвар, тухайлбал шавар, будаг, өнгөлгөө, ханын цаас зэрэг ч ордог. Хэрэв тухайн байгууламжийн гадаргуугийн өнгөлгөөг шинэчлэх, солих шаардлагатай тохиолдолд эх материал, ашигласан арга техник болон бүтцийг аль болох хуулбарлах хэрэгтэй.

8. Венецийн Хартийн 9-13 дугаар зүйлд заасанчлан, сэргээн засварлалтын ажлын гол зорилго нь түүхэн модон байгууламжийн бүтэц, даацын зориулалтыг хадгалах, бүрэн бүтэн байдлыг сайжруулах замаар түүний соёлын үнэ цэнийг илэрхийлэх, түүний эртний төлөв байдал болон хийцийг оршин байгаа түүхэн материалын нотолгоонд тулгуурлан засах юм. Түүхэн модон байгууламжийн бүтцээс хасагдсан болон одоо байгаа хэсгүүдийг каталогжуулж, онцлог шинжээр нь баримтжуулан тогтмол хадгалах хэрэгтэй.

ЗАСВАР БОЛОН НӨХӨЛТ

9. Түүхэн модон байгууламжийн өмхөрсөн, гэмтсэн хэсгүүдийг засварлахдаа тохиромжтой, сэргээн засварлалтын шаардлагыг хангасан материалыг ашиглан түүх, гоо зүйн үнэ цэнд нийцүүлэн адил материалаар орлуулж засварлаж болно.

Модон байгууламжийн аль нэг бүрэлдэхүүн, эсвэл тухайн бүрэлдэхүүний аль нэг хэсгийг засварлахдаа ижил төрлийн мод ашиглах ба орлуулж хийсэн модны хэсгийг аль болох ялгагдахуйц, дурсгалын өөрийн шинж чанарыг хадгалсан байдлаар хийнэ. Орлуулах модны чийгшил ба бусад физик шинж чанар нь үндсэн байгууламжийн бүтэцтэй тохирч байх ёстой.

Хээ чимэг хийхэд ашигласан багаж, тоног төхөөрөмж зэргийг багтаасан гар урлал болон барилгын технологийг анхны байдлаар нь

ашиглах зүйтэй юм. Шаардлагатай тохиолдолд хадаас болон бусад хоёрдогч материалыг эх хувилбарыг нь дуурайлган хувилж болно. Орлуулж хийсэн модны хэсэг уламжлалт урлал болон бүтэцтэй нийцэж байх хэрэгтэй.

10. Орлуулж хийсэн шинэ хэсгүүд байгууламжийн үндсэн хэсгээс ялгагдахуйц байх ёстой. Орлуулсан хэсгүүдэд байсан байгалийн элэгдэл эсвэл хэлбэрийн гажилтыг шинэ хэсэгт хуулбарлаж болохгүй. Орлуулж хийсэн шинэ хэсгийг уламжлалт эсвэл маш сайн туршсан шинэ арга зүйгээр байгууламжийн үндсэн хэсгийн өнгөнд тохируулж, тааруулж будах ба шинэ будаг нь модны гадаргууг гэмтээхгүй, доройтуулахгүй байх ёстой.

11. Орлуулж хийсэн шинэ хэсгүүдийг хожим танихын тулд сийлбэр хийх, эсвэл модонд шатсан тэмдэг тавьх болон бусад аргаар ялгаж тэмдэглэсэн байх ёстой.

ТҮҮХЭН ОЙН НӨӨЦ

12. Түүхэн модон барилгыг засах хадгалахын тулд барилгын мод (гуалин) бэлтгэж болохуйц ой модны нөөцийг бий болгох хамгаалах ажлыг хөхүүлэн дэмжих хэрэгтэй.

Түүхэн модон байгууламж, дурсгалт газрын хадгалалт, хамгаалалтыг хариуцсан нөхцөлд иймд ажилд мод (гуалин, дүнз)-ны дэлгүүр байгуулахыг дэмжих хэрэгтэй.

ОРЧИН ҮЕИЙН МАТЕРИАЛ БА ТЕХНОЛОГИ

13. Орчин үеийн материал болох эпокси цавуу, техник болох бүтцийг ган төмрөөр хүчитгэх зэргийг барилгын бат бөх байдал, бүтцийн төлөв байдлыг хангалттай удаан хугацаанд судалсны үндсэнд маш болгоомжтой ашиглах хэрэгтэй.

Түүхэн байгууламж болон дурсгалт газрын түүхэн болон гоо зүйн ач холбогдолыг маш сайн таньж судалсны үр дүнд халаалтын систем, гал түймрийг илрүүлэх, урьдчилсан сэргийлэх системийг суурилуулах ёстой.

14. Химийн бодисыг сайн хяналтын дор, гарах үр дүн баталгаатай, нийтийн болон хүрээлэн буй орчинд нөлөөлөхгүй, аюулгүй, мөн урт хугацааны туршид үр дүн, ач холбогдлоо үзүүлэх тохиолдолд хэрэглэнэ.

БОЛОВСРОЛ БОЛОН СУРГАЛТ

15. Түүхэн модон байгууламжийн соёлын ач холбогдол, түүний үнэ цэнтэй холбоотой боловсролын хөтөлбөрүүд нь түүнийг тогтвортой хадгалж хамгаалах болон хөгжлийн бодлогод чухал үүрэгтэй. Цаашид түүхэн модон байгууламжийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтын чиглэлээр сургалтын хөтөлбөр бий болгож, хөгжүүлэх хэрэгтэй. Энэ сургалтыг тогтвортой үйлдвэрлэл, ашиглалтын хэрэгцээнд тулгуурласан цогц стратегитайгаар орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд зохион байгуулах шаардлагатай. Эдгээр сургалтын хөтөлбөр нь архитектор, сэргээн засварлагч, инженер, гар урчууд болон дурсгал хариуцсан менежер зэрэг түүхэн модон байгууламжид хамааралтай бүхий л холбогдох мэргэжлийг хамарсан байх ёстой.

--- о О о ---

АРХИТЕКТУРЫН ӨВИЙГ ХАДГАЛЖ ХАМГААЛАХ, СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ БОЛОН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЗАРЧИМ

*ICOMOS-ийн 14 дүгээр Ерөнхий Ассамблейн хурлаар батлав.
Зимбабве Улс, Викторийн хүрхрээ. 2003 он*

БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛГО

Архитектурын өв, түүхийн дурсгал, үлдцийг (материал болон барилгын бүтцийн хувьд) орчин үеийн аргачлалаар сэргээн шинэчлэх мөн ашиглалтын зарим нөхцөлийг хязгаарлах хэд хэдэн шаардлагууд гарч ирж байна. Иймд тэдгээрт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр сэргээн засварлах ажлыг явуулах ба соёлын шинж чанарыг алдагдуулалгүй байх шаардлагыг хангаж ажиллах хэрэгтэй болж байна.

Энэхүү Зөвлөмжид хадгалж хамгаалах, сэргээн засварлах үйл ажиллагааны бүхий л шаардлага болон тухайн үед үүсч болох асуудлыг багтаасан ба шинжлэх ухааны болон соёлын мэдлэгт тулгуурласан агуулгыг өөрчлөн сольж болохгүй.

Зөвлөмжийн баримт бичиг нь хоёр хэсгээс бүрдэнэ: 1. Зарчим - хадгалж хамгаалах үндсэн ойлголт; 2. Удирдамж - зохион бүтээгчдийн (дизайнер нарын) дагаж мөрдвөл зохих дүрэм, арга зүй. Зөвхөн хөшөө дурсгал, дурсгалт газрыг хамгаалах Олон улсын зөвлөл (ICOMOS)-өөр батлагдсан баримт бичиг болно. Гарын авлага нь англи хэл дээр салангид баримт болно.

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Архитектурын өвийг хадгалж хамгаалах, бэхжүүлэх, сэргээн засварлахад олон төрлийн арга шаардагдана.
- 1.2. Архитектурын өвийн анхны дүр төрх нь үнэ цэнтэй зүйл бөгөөд түүнийг хамаагүй засаж өөрчилж болохгүй, учир нь энэ бол тухайн улс орны соёлын шууд тусгал болж байдаг учраас түүнийг хүндэтгэж, хамгаалах шаардлагатай.
- 1.3. Архитектурын өвийн үнэ цэнийг зөвхөн түүний харагдах гаднах дүр төрх байдалтай нь холбож ойлгож болохгүй. Түүний бүтэц, элемент, бүрэлдэхүүн хэсэг, баригдсан цаг хугацаа зэрэг нь үнэт зүйл болгодог.
- 1.4. Ямар нэг зорилгоор ашиглалт болон зориулалтыг өөрчлөх тохиолдолд хадгалж хамгаалах бүх шаардлага, аюулгүй байдлын нөхцөлийг сайтар анхаарч үзэх хэрэгтэй.
- 1.5. Архитектурын өвийг сэргээн засварлах ажил нь барилгыг бүрэн

бүтэн болгож дуусдаг боловч үүгээр төгсөхгүй, дуусашгүй үргэлжлэх үйл явц юм.

- 1.6. Дурсгалт барилгын онцлог, тэдгээрийн цогц түүх нь анагаах ухаантай адил тодорхой үе шаттай нарийн судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулахыг шаарддаг. Анамнез (барилгын нөхцөл байдал, барилгын түүх болон хөгжлийн мэдээлэл), оношилгоо, эмчилгээ, хяналтыг судалгааны ач холбогдол бүхий өгөгдөл болон мэдээлэл, эвдрэл гэмтэл, муудалтын шалтгаанд тулгуурлан хөндлөнгөөс ажлын бүтээмж болон хамгийн сайн арга барилыг ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьдаг. Архитектурын өвд ашиглаж буй өртөг, зардлыг үр ашигтай, хамгийн бага нөлөөтэйгөөр гүйцэтгэх нь оновчтой зам юм.
- 1.7. Архитектурын өвд хор хөнөөл болон гаднын нөлөө илэрсэн тохиолдолд яаралтай арга хэмжээ авч (тухайлбал, газар хөдлөлтийн дараа), бүтэц болон жинхэнэ хэмжээ өөрчлөгдөхөөс зайлсхийхийн тулд урьдчилсан сэргийлэх ёстой.

2. СУДАЛГАА БА ОНОШИЛГОО

- 2.1. Асуудлын хамрах хүрээ болон төрлөөс хамааран олон салбарын мэргэжилтнээс бүрдсэн багийг судалгааны эхний үе шатнаас буюу талбайд эхний судалгааг хийх, судалгааны хөтөлбөр, төлөвлөгөөг бэлтгэхээс эхлэн ажиллуулах хэрэгтэй.
- 2.2. Тухайн барилга байгууламжид тулгараад буй бодит асуудлуудыг шийдвэрлэхэд тохирсон арга хэмжээний талаар дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулахдаа юуны түрүүнд байгаа мэдээлэл, өгөгдлүүдийг зөв зүйтэй боловсруулах хэрэгтэй.
- 2.3. Дурсгалыг хадгалж хамгаалах практикт бүтэн болон материалын онцлог шинжийг бүрэн ойлгосон байхыг шаарддаг. Анхны хэлбэр нь ямар байсан, барьж байгуулахад ямар техник ашигласан, ямар ямар өөрчлөлтүүд хийгдэж байсан хийгээд тэдгээр нь ямар нөлөө үзүүлсэн мөн өнөөгийн нөхцөл байдал ямар байгаа талаар мэдээлэлтэй байх нь чухал.
- 2.4. Археологийн талбайд тодорхой асуудал үүсэж болзошгүй тул малтлага бүрэн дуусаагүй байхад бүтцийг тогтворжуулах хэрэгтэй болдог.
Малтаж гаргасан барилга байгууламж нь газар дээр ил байсан барилгатай харьцуулбал бүтцийн хувьд ихээхэн өөрчлөлтөд ордог.

- Иймд тухайн талбай дээр авах аливаа яаралтай арга хэмжээ нь барилгын хэлбэр, ашиглалтын бүрэн бүтэн байдлыг алдагдуулж болохгүй.
- 2.5. Түүхийн, чанарын болон тоон арга дээр тулгуурлан оношилгоо явуулна. Чанарын арга нь түүхийн болон археологийн судалгаа, бүтцийн эвдрэл гэмтэл, материалын элэгдэл муудалт зэрэгт суурилсан байдаг бол тоон арга нь материал болон бүтцийн туршилт, үнэлгээ, бүтцийн шинжилгээ зэрэгт суурилсан байна.
 - 2.6. Шийдвэр гаргахаас өмнө эвдрэл гэмтэл болон муудалтын шалтгааныг тодорхойлох нь чухал бөгөөд дараа нь барилгын аюулгүй байдлын түвшнийг үнэлэх зайлшгүй шаардлагатай.
 - 2.7. Оношилгооны хамгийн сүүлчийн үе шат болох аюулгүй байдлыг үнэлэх үед засварын арга хэмжээ шаардлагатай эсэхийг тодорхойлно. Ингэхдээ чанарын болон тоон шинжилгээ буюу шууд ажиглалт, түүхэн судалгаа, болон бүтцийн шинжилгээ, шаардлагатай бол туршилт, сорилт хийж хооронд нь уялдуулан авч үзнэ.
 - 2.8. Шинэ барилга барих үед баримталдаг аюулгүйн түвшнийг ашиглахад ихэнхдээ илүү нарийн арга хэмжээ авах шаардлагатай болдог. Энэ тохиолдолд аюулгүй байдлыг хангаж чадах өөр өөр арга, замуудыг тодорхойлохын тулд тусгай шинжилгээ хийж болно.
 - 2.9. Олж авсан мэдээлэл, аюулгүй байдлын үнэлгээ, оношилгоо, үйл ажиллагаа явуулах шийдвэр зэрэг холбоотой асуудлууд “Тайлбар бичиг”-г (Explanatory Report) бичигдсэн байх ёстой.

3. СЭРГЭЭН ЗАСАХ БА ХЯНАЛТ

- 3.1. Сэргээн засахын тулд эвдрэлийн үндсэн шалтгааныг илрүүлэх нь эвдрэлийг олохоос илүү чухал.
- 3.2. Хамгийн сайн эмчилгээ бол урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээ юм.
- 3.3. Аюулгүй байдлын үнэлгээ ба барилгын ач холбогдлыг ойлгох нь цаашдын хадгалж хамгаалах, бэхжүүлэх үйл ажиллагааны үндэс болох ёстой.
- 3.4. Зайлшгүй хийх шаардлагатай гэсэн баримт нотолгоогүй бол ямар нэгэн арга хэмжээ авах ёсгүй.
- 3.5. Аливаа арга хэмжээ нь аюулгүй байдлын зорилтод нийцсэн байх ёстой, тэдгээр зорилт нь дурсгалын үнэ цэнд хамгийн бага хор

нөлөө үзүүлэхээр байх ёстой.

- 3.6. Эвдрэл гэмтэл, муудалтын шалтгаан болж байсан үйл ажиллагааны төрлүүдийг ойлгож, цаашлаад тухайн барилга, байгууламжид үйл ажиллагаа явуулсны дараа гарах үр дагавруудыг харгалзан үзсэний үндсэн дээр хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулна.
- 3.7. Тухайн тохиолдол, нөхцөл байдал бүрээс хамааран “уламжлалт” болон “шинэ” техник технологийг зөв зүйтэй хослуулан ашиглах хэрэгтэй. Ингэхдээ тухайн аргуудын дурсгалын үнэ цэнд хамгийн бага хохирол учруулах, аюулгүй, найдвартай байдлыг хангахыг илүүд үзэх хэрэгтэй.
- 3.8. Аюулгүй байдлын үнэн бодит байдал болон боломжит үр нөлөөг үнэлэхэд бэрхшээлтэй байгаа үед “ажиглалтын арга”-ыг санал болгоно. Өөрөөр хэлбэл, нэмэлт буюу засаж залруулах арга хэмжээний хамгийн бага түвшнээс эхлэн өсөн нэмэгдэх арга барилыг хэрэглэнэ.
- 3.9. Аливаа авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь шинэ мэдлэг, мэдээлэл олж авсан тохиолдолд өөр илүү тохиромжтой аргаар сольж, орлуулах боломжтой “хоёр талтай” байх ёстой. Бүгдийг сольж, орлуулах боломжгүй тохиолдолд дараагийн үйл явцыг хязгаарлахгүй байх.
- 3.10. Сэргээн засварлах ажилд хэрэглэх материалын шинж чанар нь (тухайлбал, шинэ материал) хуучин байгаа материалтай зохицох байдлыг сайтар нягтлах хэрэгтэй. Ялангуяа урт хугацаанд ямар нөлөө үзүүлж болохыг нягталснаар гарч болох сөрөг нөлөөнөөс сэргийлнэ.
- 3.11. Тухайн барилга болон түүний хүрээлэн буй орчны ялгаатай шинж чанар, тэдгээрийн эх болон эртний байдлыг устгаж болохгүй.
- 3.12. Тухайн дурсгалд хийгдэж байгаа ажил бүр нь барилгын анхны төрх байдал, үзэл баримтлал, арга барил буюу техник, түүхэн үнэ цэнийг хүндэтгэсэн, түүнийг ирээдүйд нотлох үл мөр, баримтыг хадгалан үлдээхэд чиглэгдсэн байна.
- 3.13. Тухайн дурсгалд хийгдэж байгаа аливаа ажил нь архитектурын, бүтцийн, суурилуулалтын болон функцийн гээд уг зүйлийн бүхий л талуудыг харгалзан үзсэн нэгдсэн төлөвлөгөөний үр дүн байх ёстой.
- 3.14. Аливаа түүхэн материал, архитектурын онцлог шинж чанарыг арилгах болон өөрчилж болохгүй.

- 3.15. Муудсан барилгыг шинээр солихоосоо илүү аль болох засварладаг байх ёстой.
- 3.16. Барилгын түүхийн нэг хэсэг болсон бүрэн бус байдал, өөрчлөлтийг хадгалан авч үлдэх нь аюулгүй байдлын шаардлагатай зөрчилдөхгүй.
- 3.17. Материал болон бүтцээс хамааран өөр аргаар хадгалж хамгаалах боломжгүй эсвэл хохирол учруулахаар байгаа нөхцөлд түүнийг буулгаж, дахин угсрах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.18. Түр хамгаалалтын системийг үйл ажиллагааны явцад үнэт дурсгалд ямар нэг хохирол учруулахгүйн тулд ашиглана.
- 3.19. Аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэх санал дэвшүүлэхдээ ажлын явцад авч хэрэгжүүлэх хяналтын хөтөлбөр хавсаргасан байх хэрэгтэй.
- 3.20. Ажил гүйцэтгэлийн явцад хянах боломжгүй арга хэмжээ явуулах, авч хэрэгжүүлэхийг хориглоно.
- 3.21. Үр дүнгийн үр нөлөөг тодорхойлохын тулд үйл ажиллагааны явцад болон дараа нь хяналт шалгалтыг хийнэ.
- 3.22. Хяналт, шалгалтын бүхий л үйл ажиллагааны тухай тэмдэглэл хөтлөх ба түүнийг барилгын түүхийн нэг хэсэг болгон хадгална.

БУРРАГИЙН ХАРТИ

(2013 оны Австралийн ICOMOS-ийн Соёлын ач холбогдол бүхий дурсгалт газрын Хартти) Буррагийн Хартти нь 1979 онд Өмнөд Австралийн уурхайн хот Буррад анхлан баглагдсан. Жижиг хэмжээний нэмэлт засварыг 1981 болон 1988 онд хийсэн ба хамгийн том хэмжээний өөрчлөлтөийг 1999 онд хийсэн. Дараах хувишбарыг 2013 оны 10 дугаар сард Австралийн ICOMOS-ийн хурлаар баталсан.

Өмнөх үг

Хөшөө дурсгал, дурсгалт газруудыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах тухай Олон улсын Хартти (Венец, 1964), Хөшөө дурсгал, дурсгалт газрын Олон улсын зөвлөл (ICOMOS)-ийн 5 дугаар Ерөнхий Чуулганы Шийдвэр (Москва, 1978)-ийг харгалзан үзэж Буррагийн Харттийг 1979 оны 8 дугаар сарын 19-ний өдөр Австралийн ICOMOS (Австралийн ICOMOS-ийн Үндэсний Хороо) батлав. Шинэчлэлтийг 1981 оны 2-р сарын 23, 1988 оны 4-р сарын 23, 1999 оны 11-р сарын 26, 2013 оны 10-р сарын 31-нд батлав.

Буррагийн Хартти нь соёлын ач холбогдол бүхий дурсгалт газар (соёлын өвийн газар)-ын хадгалалт хамгаалалт, менежментийг удирдамжаар хангах зорилготой бөгөөд Австралийн ICOMOS-ийн гишүүдийн мэдлэг, туршлагад суурилсан болно.

Хадгалалт хамгаалалт нь соёлын ач холбогдолтой газруудын менежментийн салшгүй хэсэг бөгөөд байнгын үүрэг хариуцлага юм.

Хартийг хэнд зориулсан бэ?

Соёлын ач холбогдол бүхий газруудад зөвлөгөө өгөх, шийдвэр гаргах эсвэл үйл ажиллагаа хэрэгжүүлдэг өмчлөгч, менежер болон хамгаалагч нарт дадлага олгох стандарт бий болгох зорилгоор бүтээв.

Хартийг хэрэглэх

Энэхүү Хартти олон хэсгээс бүрдэх ч нэг цогц болгож унших шаардлагатай юм.

Харти дараах агуулгатай:

- Тодорхойлолт
 - Хадгалалт хамгаалалтын зарчим
 - Хадгалалт хамгаалалтын үйл явц
 - Хадгалалт хамгаалалтын туршлага
 - Буррагийн Хартийг хэрэгжүүлэх “Явц”-ын бүдүүвч.
- Энэхүү Хартийн үндсэн үзэл баримтлалыг хадгалалт хамгаалалтын зарчмын хэсэгт оруулснаас гадна хадгалалт хамгаалалтын үйл явц, хадгалалт хамгаалалтын туршлага хэсэгт илүү боловсронгуй болгож оруулав. Буррагийн Хартийг хэрэгжүүлэх “Явц”-ын график нь тус Хартийн салшгүй нэг хэсэг болно. Мөн тайлбар тэмдэглэл нь энэхүү Хартийн хэсэг болно.
 - Хартиг ашиглахтай холбодлолтой мэдээллийг Австралийн ИКОМОС-ийн практик тэмдэглэл, Буррагийн Хартийн Зурагт тайлбар болон australia.icomos.org. цахим хуудаст байх бусад заавар баримт бичигт дэлгэрэнгүй тайлбарласан бол

Хартийг ямар газарт ашиглах вэ ?

Энэхүү Хартийг уугуул, түүхэн газар зэрэг соёлын үнэ цэнэ, ач холбогдол бүхий бүхий л газруудад ашиглаж болно. Энэхүү Хартид Австралийн Байгалийн Өвийн Харти, Эхэлж асуу: уугуул өвийн дурсгалт газар, үнэт зүйл болон ач холбогдлыг таньж, хүндэтгэх гарын авлага 2.0: цуглууллын ач холбогдлыг үнэлэх гарын авлага зэрэг бусад байгууллагуудын стандарт хамааралтай байж болно.

Үндэсний болон Олон улсын Харти болон бусад бодлогын баримт бичиг хамааралтай байж болно. Дэлгэрэнгүйг Australia.icomos.org сайтаас үзнэ Үг.

Яагаад хадгалж, хамгаалах?

Соёлын ач холбогдол бүхий газар нь хүмүүсийн амьдралыг баялаг болгохын зэрэгцээ тэднийг үргэлж хам бүлэг, байгаль дэлхий, өнгөрсөн хийгээд амьдралаас гарсан туршлагатай гүн гүнзгий холбож өгч байдаг. Тэдгээр нь Австралийн онцлог шинж чанар, туршлагын чухал илэрхийлэл болсон түүхэн дурсгал юм.

Соёлын ач холбогдол бүхий газар нь манай хам бүлгийн олон төрөл, бид хэн болох, бидний бүтээсэн өнгөрсөн үе болон Австралийн газар нутгийн тусгал болдог бөгөөд тэдгээр нь нөхөгдөшгүй, үнэ цэнтэй юм.

Эдгээр соёлын ач холбогдол бүхий газар нь үе дамнанас өмчийн зарчмаар одоо болон ирээдүй үед хадгалагдаж үлдэх ёстой.

"Өөрчлөлт" гэх ойлголттой маш болгоомжтой хандахыг Буррагийн Харти чухалчилдаг. Дурсгалт газрыг шаардлагатай хэмжээнд хамгийн сайнаар арчлах, ашиглаж болохуйц байлгах болон соёлын ач холбогдлыг хадгалахын тулд аль болох бага өөрчлөхийг чухалчилдаг.

Зүйл 1. Тодорхойлолт

Хартийн зорилго:

1.1. Газар гэж газарзүйн хувьд тодорхойлогдсон орон зайг хэлнэ. Үүнд элемент хэсгүүд, объект, орон зай болон харагдах байдалбагтана. Газар нь биет болон биет бус хэмжээст байж болно.

1.2 Соёлын ач холбогдол гэдэг нь өнгөрсөн, одоо эсвэл ирээдүй хойч үед гоо зүйн, түүхэн, шинжлэх ухааны, нийгмийн эсвэл оюун санааны үнэ цэнтэй байхыг хэлнэ.

Соёлын ач холбогдол нь тухайн газар, түүний бүтэц, орчин, хэрэглээ, дурсамж, утга учир, бүртгэл, холбогдох газрууд болон объектод тусгагдсан байдаг.

Газар нь байгалийн болон соёлын шинж чанарыг агуулсан өргөн хүрээтэй. Газар нь том, жижиг байж болно. Жишээ нь: Дурсгалын, мод, дан барилга эсвэл цогцолбор барилга, түүхэн үйл явдал болсон газар, хот болон суурин, соёлын орон зай, цэцэрлэг, аж үйлдвэрийн, усан онгоц сүйрсэн газар, туурь, чулуун байгууламж, засмал зам болон аяллын зам, олон нийтийн уулзалтын цэг, оюун санаа болон шашны холбогдол бүхий газар.

"Соёлын ач холбогдол" гэдэг нэршил нь соёлын өвийн ач холбогдол, соёлын өвийн үнэ цэнтэй адил угтгай.

Дурсгалт газар нь хувь хүн болон бүлэгт харилцан адилгүй үнэ цэнтэй байж болно.

1.3 Бүтэц, гэдэг нь тухайн дурсгалын бүхий л бодит материал, бүрэлдэхүүн хэсэг, бэхлэгээ болон доторх эд зүйлсийг хэлнэ.

1.4 Хадгалалт хамгаалалт гэдэг нь соёлын ач холбогдлыг авч үлдэх зорилгоор арчлах бүхий л үйл явц.

1.5 Засвар, үйлчилгээ гэдэг нь тухайн газар болон түүний орчныг тогтмол арчилж хамгаалахыг хэлнэ. Засвар нь сэргээх явцаас (сэргээн засварлалт болон сэргээн босголтыг хамаатуулан үздэг) ялгаатай юм.

1.6 Хадгалалт гэдэг нь дурсгалыг оршин байгаа байдлаар нь засах болон элэгдлийг удаашруулах явцыг хэлнэ.

Соёлын ач холбогдол нь цаг хугацаа, хэрэглээний аясаар өөрчлөгдөж болно. Шинэ мэдээллийн үр дүнд соёлын ач холбогдлын талаарх ойлголт өөрчлөгдөж болно.

Бүтэцэд барилгын дотор тал, газрын хэвлий дэх эд зүйлс, малтлагаар илэрсэн олдворууд багтана. Тухайн газарт байх байгалийн элемент ч бүтцийн нэг хэсэг байж болно. Жишээ нь: Тахилга, шүтлэгт газрыг илтгэх хад чулуу.

Бүтэц нь мөн орон зай болон харагдах байдлыг тодорхойлж болох бөгөөд эдгээр нь тухайн газрын ач холбогдлын нэг хэсэг байж болно. 14 дүгээр зүйлийг харна уу.

Хамгаалалтын арчилгааны жишээнүүд:

- засвар, үйлчилгээ - дурсгалыг тогтмол хянаж, цэвэрлэх гэх мэт. Цэцэрлэгийг тайрах, хадгаж янзлах гэм мэт.
- Засвар орлоцуулсан сэргээн засварлалт — байрнаасаа хөдөлсөн эсвэл өөр газарт байршуулсан бүтцийг өмнөх төрх байдалд оруулах г.м. барилгын дээврийн суваг унах эсвэл нутгийн уугуул иргэдийн тойрог хэлбэрийн чулуун байгууламжийн нэг хэсэг зөөгдөх;
- Засвар орлоцуулсан сэргээн босголт — элэгдсэн бүтцийг шинэ бүтцээр солих. Бүхий л дурсгалт газар болон тэдний бүрэлдэхүүн хэсгүүд цаг хугацааны явцад олон янз байдлаар элэгддэг.

<p>1.7. Сэргээн засварлалт гэдэг нь дурсгалын орчимд ургасан ургамал болон дарагдсан хурдсыг цэвэрлэх замаар түүнийг өмнөх байдалд нь оруулах эсвэл шинэ материал ашиглахгүйгээр дурсгалын одоо байгаа хэсгүүдийг эвлүүлэх.</p> <p>1.8. Сэргээн босголт гэдэг нь дурсгалыг өмнөх төрх байдалд нь оруулах бөгөөд шинэ материал ашигласнаараа сэргээн засварлалтаас ялгардаг.</p>	<p>Шинэ материалд бусад газраас авсан дахин боловсруулсан материалыг оруулж болно. Энэ нь соёлын ач холбогдол бүхий аль ч газарт хохирол учруулах ёсгүй.</p>
<p>1.9. Шинэчлэн өөрчлөх гэдэг нь одоо байгаа болон санал болгож буй хэрэглээнд нийцүүлэн тухайн газрыг өөрчлөхийг хэлнэ.</p> <p>1.10. Ашиглалт гэдэг нь Тухайн газрын зориулалтыг хэлэх бөгөөд тухайн газар болон тухайн газраас хамааралтай үйл ажиллагаа, уламжлалт болон заншил багтдаг.</p> <p>1.11. Зохиост хэрэглээ гэдэг нь тухайн газрын соёлын ач холбогдлыг хүндэтгэхийг хэлнэ. Ийм хэрэглээ нь соёлын чухал ач холбогдолд хамгийн бага эсвэл огт нөлөө үзүүлдэггүй.</p>	<p>Ашиглалтад уугуул иргэдтэй нийтлэг холбоотой соёлын зан үйл болох тухайлбал ан алнах, загас барих болон уламжлалт үүргээ ёсчлон биелүүлэх зэрэг ёслол багтана. Нэвтрэх эрхээ хэрэгжүүлэх нь ашиглалт байж болно.</p>
<p>1.12. Орчин гэдэг нь соёлын ач холбогдол бүхий тухайн газрын хэсэг эсвэл түүний соёлын ач холбогдол, өвөрмөц шинж чанарт хувь нэмэр оруулдаг газрын ойрын болон өргөтгөсөн орчин.</p> <p>1.13. Холбогдох газар гэдэг нь өөр газрын соёлын ач холбогдолд хувь нэмэр оруулж буй газрыг хэлнэ.</p>	<p>Орчинд: бүтэц, орон зай, газар, ус болон тэнгэр; дурсгалт газарт харагдах байдал, соёлын замын дагуух харагдах болон тухайн орчинтой хамааралтай мэдрэхүйн хэв шинж; Тухайлбал, үнэр болон дуу чимээ багтана. Мөн орчинд түүхэн болон орчин цагийн харилцаа, тухайлбал ашиглалт, үйл ажиллагаа, нийгмийн болон оюун санааны дадал зуршил, бусад газартай хамаарах биет болон биет бус холбоо хамаарал.</p>
<p>1.14. Холбогдох объект гэдэг нь тухайн газарт байхгүй хэдий</p>	<p>Объект нь тухайн газрын тодорхойлолтод</p>

ч тухайн газрын соёлын ач холбогдолд хувь нэмэр оруулж буй эд зүйлийг хэлнэ.

1.15. *Холбоо хамаарал* гэдэг нь хүмүүс болон тухайн газрын дунд орших холбоо хамаарал юм.

1.16 *Утга учир* гэдэг нь тухайн газар хүмүүст юуг бэлгэдэх, харуулах, санагдуулах, илэрхийлэхийг хэлнэ.

1.17 *Тайлбар* гэдэг нь тухайн газрын соёлын ач холбогдлыг танилцуулах бүхий л аргыг хэлнэ.

ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ЗАРЧМУУД

Зүйл 2. Хадгалалт хамгаалалт ба менежмент

2.1 Соёлын ач холбогдол бүхий газрыг хадгалж хамгаалах ёстой.

2.2 Хадгалалт хамгаалалтын зорилго нь соёлын ач холбогдлыг авч үлдэх юм.

2.3 Хадгалалт хамгаалалт нь соёлын ач холбогдол бүхий газруудын сайн менежментийн салшгүй нэг хэсэг юм.

2.4 Соёлын ач холбогдол бүхий газруудыг хамгаалах ёстой ба эрсдэлд оруулах эсвэл эмзэг байдалд орхихгүй байх ёстой.

хамаардаг ба түүний соёлын ач холбогдолд хувь нэмэр оруулдаг эсвэл оруулдаггүй ч байж болно.

Холбоо хамааралд нийгмийн болон оюуны үнэт зүйлд, тухайн дурсгалт газартай холбоотой соёлын үүрэг хариуцлага багтана.

Утга учир нь ерөнхийдөө бэлэгдэлийн чанар, дурсамж зэрэг биет бус хэмжигдэхүүнтэй холбоотой байдаг.

Тайлбар нь бүтцийг арчлахтай холбоотой хосолмол үйл ажиллагаа (засвар, сэргээн засварлалт, сэргээн босголт г.м) дурсгалт газар дахь үйл ажиллагаа болон ашиглалт, танилцуулга, тайлбар материалын хэрэглээ байж болно.

Зүйл 3. Болгоомжлох хандлага

3.1. Хадгалалт хамгаалалт нь оршин байгаа бүтэц, ашиглалт, хамаарал болон утга агуулгыг хүндэтгэхэд суурилдаг. Шаардлагатай өөрчлөлтийг хийхдээ маш болгоомжтой хандах, аль болох бага өөрчлөхийг шаарддаг.

3.2. Дурсгалт газрыг өөрчлөхдөө түүний физик шинж чанар болон бусад нотолгоог гажуудуулахгүй байх, таамаглалд үндэслэхгүй байх.

Зүйл 4. Мэдлэг, ур чадвар ба арга техник

4.1. Хадгалалт хамгаалалтад тухайн газрыг судлах, арчлахад хувь нэмэр оруулах бүхий л мэдлэг, ур чадвар, зарчмыг ашиглана.

4.2. Ач холбогдол бүхий бүтцийг хадгалж хамгаалахдаа уламжлалт арга техник, материалыг ашиглахыг чухалчилна. Зарим тохиолдолд хадгалалт хамгаалалтын үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор орчин үеийн арга техник болон материалыг ашиглаж болно.

Зүйл 5. Үнэ цэнэ

5.1. Хадгалалт хамгаалалт нь аль нэг үнэ цэнийг онцлохгүйгээр тухайн дурсгалын байгалийн болон соёлын ач холбогдлыг бүхий л талаар нь тогтоож, анхааралдаа авахыг хэлнэ.

Дурсгалын бүтэц дэх нэмэлт, өөрчлөлт болон хуучин засварын үл мөн нь түүний түүхийн нотолгоо болох бөгөөд түүний ач холбогдлын нэг хэсэг байж болно. Хадгалалт хамгаалалтын үйл ажиллагаа нь дурсгалын талаарх ойлголтод саад хийх бус дэмжлэг үзүүлэх ёстой.

Орчин үеийн материал техникийг ашиглахдаа ШУ-ы баттай нотолгоо эсвэл туршлагаар баталгаажуулсан байх ёстой.

Байгалийн ач холбогдол бүхий дурсгалын хадгалалт хамгаалалтыг Австралийн Байгалийн Өвийн Хартид тайлбарласан. Энэхүү Хартид байгалийн ач холбогдол гэдэгт экосистем, биологийн олон төрөл зүйл болон геологийн олон төрөл зүйлийн оршихуйн үнэ цэнэ эсвэл тэдгээрийн одоо болон ирээдүй

үед үзүүлэх шинжлэх ухаан, нийгэм, гоо зүй, амьдрах чадварыг сэргээх үнэ цэнэ, түүний ач холбогдол багтана.
Зарим соёлд байгалийн болон соёлын үнэ цэнийг ангилдаггүй.

Соёлын ач холбогдлын талаарх ойлголт өөрчлөгдөж магадгүй тул болгоомжтой хандах хэрэгтэй. Соёлын ач холбогдлыг хадгалж, хамгаалаагүй аливаа үйлдэлд энэхүү заалтыг ашиглах ёсгүй.

Буррагийн Хартийн үйл явц, эсвэл шинжлэлт судлах дараалал, шийдвэр болон үйл ажиллагааг доор харуулав. Илүү дэлгэрэнгүйг Хартийг дагалдах хүснэгтэд тайлбарлав.

Ач холбогдлыг ойлгох

Бодлогыг сайжруулах

Бодлогын дагуу зохицуулалтыг хийх

5.2. Соёлын ач холбогдлын харьцангуй байдал нь дурсгалт газарт өөр өөр хадгалалт хамгаалалтын үйл ажиллагааг явуулахад хүргэж болно.

Зүйл 6. Буррагийн Хартийн ажиллах зарчим

6.1. Шийдвэр гаргахын өмнө тухайн газрын соёлын ач холбогдол болон түүний ирээдүйд нөлөөлөхүйц бусад асуудлыг мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх дарааллаар хамгийн сайн ойлгох хэрэгтэй. Нэгдүгээрт соёлын ач холбогдлыг ойлгох, хоёрдугаарт бодлого боловсруулах, эцэст нь тухайн бодлогын дагуу менежментийг хэрэгжүүлэх нь Буррагийн Хартийн ажиллах зарчим юм.

6.2. Дурсгалт газрыг зохицуулах бодлого нь тухайн газрын соёлын ач холбогдлын ойлголт дээр тулгуурласан байх ёстой.

6.3 Бодлого боловсруулахдаа тухайн дурсгалт газрын ирээдүйд нөлөөлөхүйц хэв шинж, жишээлбэл, эзэмшигчийн хэрэгцээ, нөөц, гадаад орчноос хамааралтай хязгаарлалт болон дурсгалт газрын физик нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай.

6.4 Үр дүнтэй бодлого боловсруулахад соёлын ач холбогдлыг авч үлдэх олон янзын арга замыг судлах, мөн тодруулах шаардлагатай бусад хэв шинжийг мөн тодорхойлох хэрэгтэй.

6.5 Нөхцөл байдал, шинэ мэдээлэл, хэтийн төлөв өөрчлөгдөхөд Бурагайн Хартийг хэсэгчлэн болон бүхэлд дахин давтан хэрэгжүүлэх шаардлага гарч болно.

Зүйл 7. Ашиглалт

7.1 Тухайн газрын ашиглалт нь соёлын ач холбогдолтой бол түүнийг мөн хадгалах ёстой.

7.2 Тухайн газрын ашиглалт зохистой байх ёстой.

Харгалзан үзсэн сонголтод дурсгалт газрыг ашиглах, өөрчлөх (Ж нь: Дасан зохицох г.м) багтаж болно.

Бодлого нь ашиглалт хосолмол ашиглалт эсвэл тухайн газрын соёлын ач холбогдлыг хадгалсан хэрэглээний хязгаарлалтыг тогтоох ёстой. Дурсгалт газрын шинэ ашиглалт нь дурсгалын бүтэц болон ашиглалтад өөрчлөлтийг хамгийн бага үзүүлэх, холбоо хамаарал болон утгыг хүндэтгэх; дурсгалын соёлын ач холбогдолд хувь нэмэр оруулахуйц үйл ажиллагаа, дадал зуршлыг зохих тохиолдолд үргэлжлүүлэх ёстой.

1.12 дугаар зүйлд орчныг илүү тодорхой тайлбарласан.

Зүйл 8. Орчин

Хадгалалт хамгаалалт нь орчныг зохистой хадгалахыг шаарддаг. Зохист орчин гэдэгт нүдэнд харагдах болон мэдрэхүүд мэдрэгдэх орчин, мөн тухайн газрын соёлын ач холбогдолд хувь нэмэр оруулж буй оюуны болон бусад соёлын харилцаа орно.

Тухайн орчин болон харилцаанд сөргөөр нөлөөлөх шинэ барилгажилт, нураалт болон бусад өөрчлөлтийг хийх нь тохиромжгүй.

Зүйл 9. Байршил

9.1 Тухайн газрын бодит байршил нь түүний соёлын ач холбогдлын нэг хэсэг байдаг. Дурсгалт барилга болон дурсгалын бусад бүрэлдэхүүн хэсгүүд өөрийн түүхэн байршилдаа оршиж, үлдэх ёстой. Тухайн дурсгалыг хамгаалахад үлдсэн цорын ганц сонголт л биш бол байршлыг өөрчлөхийг зөвшөөрдөггүй.

9.2 Зарим барилга, бүтээл болон дурсгалын бүрэлдэхүүн хэсгүүдийг хялбархан зөөх зориулалттай барьсан байх ба зарим нь аль хэдий нь дахин байршуулагдсан түүхтэй байдаг. Ийм барилга, бүтээл эсвэл бүрэлдэхүүн хэсгүүд одоогийн байршилтайгаа нягт холбоогүй тохиолдолд нүүлгэх нь тохиромжтой юм.

9.3 Хэрэв ямар нэг барилга, бүтээл болон дурсгалын бүрэлдэхүүн хэсгүүдийг нүүлгэсэн тохиолдолд тэдгээрийг зохих байршилд шилжүүлэн, ашиглалтыг нь хангаж өгөх ёстой. Энэ төрлийн үйл ажиллагаа нь соёлын ач холбогдол бүхий ямар ч газарт хор хөнөөл учруулах ёсгүй.

Зүйл 10. Бүрэлдэхүүн хэсгүүд

Тухайн газрын соёлын ач холбогдолд хувь нэмэр оруулдаг бүрэлдэхүүн хэсэг, тоноглол, эд зүйлсийг тухайн газарт л хадгалах

Жишээ нь: эд зүйлийг эх газарт нь буцаан байршуулах нь уугуул нутгийн соёлд ач холбогдолтой байж болох ба түүний соёлын

ач холбогдлыг хадгалахад нэн чухал байж болох юм.

Жишээ нь: археологийн малтлагын явцад чухал ач холбогдолтой бүтэц эвдэрч, сүйдэж болзошгүй талаар 28 дугаар зүйлд тусгасан болно.

Чухал ач холбогдолтой бүтцийг дурсгалт газраас нүүлгэсэн талаар 33 дугаар зүйлд тусгасан болно.

хэрэгтэй. Тэдгээрийн хадгалалт хамгаалалтыг хангах цорын ганц арга, түр хугацаагаар арчлах, үзэсгэлэн гаргах, эсвэл соёлын шалтгаан, эсвэл эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөө, эсвэл тухайн газрыг хамгаалах зэргээс бусад тохиолдолд дурсгалт газраас нүүлгэхийг зөвшөөрдөггүй. Бүрэлдэхүүн хэсэг, тоноглол болон объектийг нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд байсан орчин, нөхцөл, эх төрхөд буцаан байршуулах нь соёлын хувьд оновчтой юм.

Зүйл 11. Холбогдох газар болон эд зүйлс

Тухайн газрын соёлын ач холбогдолд хувь нэмэр оруулж буй газар болон объект хамгаалах ёстой.

Зүйл 12. Оролцоо

Дурсгалт газрыг хамгаалах, таниулах, удирдахдаа тухайн газар холбоо хамааралтай, утга учиртай эсвэл тухайн газарт нийгмийн, оюун санааны болон бусад соёлын үүрэг хүлээсэн хүмүүсийн оролцоог хангах ёстой.

Зүйл 13. Соёлын үнэ цэн зэрэгцэн оршихуй

Соёлын үнэт зүйлсийн зэрэгцэн оршихуйг үргэлж хүлээн зөвшөөрч, хүндэтгэж, дэмжиж байх ёстой. Ялангуяа хоорондоо зөрчилдөх тохиолдолд хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх нь онцгой ач холбогдолтой юм.

Зарим газарт соёлын үнэт зүйлс хоорондоо зөрчилдөж байгаа нь бодлого боловсруулах, менежментийн шийдвэр гаргахад нөлөөлж болзошгүй юм. 13 дугаар зүйлд тодорхойлсноор, соёлын үнэт зүйл гэдэг нь улс төр, шашин, оюун санаа болон ёс зүйн илтэл үнэмшлийг багтаасан, гэхдээ эдгээрээр хязгаарладаггүй соёлын бүлэгт чухал ач

холбогдолтой итгэл үнэмшлийг хэлнэ. Энэ нь соёлын ач холбогдлоос өргөн хүрээтэй.

Соёлын ач холбогдолд өөр заавар зөвлөгөө заагаагүй тохиолдолд хадгалалт хамгаалалт нь ихэвчлэн элэгдлийг удаашруулахыг зорьдог. Хадгалалт хамгаалалт хийхийн тулд ямар ч үйлдэл хийх шаардлагагүй нөхцөл байдал байж болно.

Өөрчлөлт, түүний дотор түр зуурын ашиглалтыг авч үзэх үед соёлын ач холбогдлыг ямар нэгэн байдлаар бууруулахгүй байх боломжийг хайж олох хэрэгтэй.

Дурсгалт газрын соёлын утга болон дадал зуршилд өөрчлөлт орж байгаа газарт өөрчлөлтийг хийх нь зохимжтой байж болох ч дурсгалт газрын соёлын ач холбогдлыг үргэлж хүндэтгэх ёстой.

Буцаах өөрчлөлтийг харгалзан үзээний эцэст түр зуурын байдлаар хийнэ. Буцаах боломжгүй өөрчлөлтийг зөвхөн эцсийн арга

ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

Зүйл 14. Хадгалалт хамгаалалтын үйл явц

Тодорхой нөхцөл байдлын дагуу, ашиглалтыг хадгалах буюу дахин нэвтрүүлэх, холбоо хамаарал, утгыг хадгалах, засвар хийх, урьдчилан хамгаалах, сэргээн засварлах, сэргээн босгох, дасан зохицох, тайлбарлах болон эдгээр үйл ажиллагааны хосолмол үйл явц зэргийг хадгалалт хамгаалалтад багтаадаг. Хадгалалт хамгаалалтад мөн дурсгалт газрын соёлын ач холбогдлыг бий болгоход холбогдох газар болон эд зүйлийн оруулах хувь нэмрийг хадгалахыг хамааруулдаг.

Зүйл 15. Өөрчлөлт

15.1 Соёлын ач холбогдлыг бууруулахгүйгээр соёлын ач холбогдлыг авч үлдэхэд өөрчлөлт шаардлагатай байж болно. Тухайн газар, түүний ашиглалтыг өөрчлөхдөө түүний соёлын ач холбогдол болон зохих тайлбарыг харгалзан үзнэ.

15.2 Соёлын ач холбогдлыг бууруулж буй өөрчлөлтийг буцааж засаж болохоор хийх ёстой бөгөөд тухайн нөхцөлд байдал

зөвшөөрсөн тохиолдолд өмнөх төрх байдалд оруулна.

15.3 Дурсгалт газарт чухал ач холбогдолтой бүтцийг нураахыг ерөнхийд нь зөвшөөрдөггүй. Гэсэн хэдий ч зарим тохиолдолд хадгалалт хамгаалалтын шаардлагаар бага хэмжээгээр нураах эсвэл нүүлгэн шилжүүлж болох юм. Нүүлгэн шилжүүлсэн бүтцийг хадгалалт хамгаалалтын үйл ажиллагаа дуусгавар болоход өмнөх төрх байдалд нь оруулах ёстой.

15.4 Дурсгалт газрын соёлын ач холбогдолд хувь нэмэр оруулж буй бүхий л хэв шинжийг хүндэтгэж үзэх ёстой. Дурсгалт газар нь түүхийн олон үе эсвэл соёлын ач холбогдлын олон хэв шинжийг агуулсан бүтэц, ашиглалт, холбоо хамаарал эсвэл утгатай байх тохиолдолд орхигдсон, нүүлгэн шилжүүлсэн, ач холбогдол нь багассан эсвэл онцолж, тайлбарласан нь илүү соёлын ач холбогдолтой биш л бол аль нэг цаг үе эсвэл хэв шинжийг онцлон танилцуулж болохгүй.

Зүйл 16. Засвар арчилгаа

Засвар арчилгаа нь хадгалалт хамгаалалтын үндэс суурь юм. Засвар арчилгааг соёлын ач холбогдол оршин байгаа бүтэц бүхэнд хийх хэрэгтэй бөгөөд засвар үйлчилгээ нь тухайн соёлын ач холбогдлыг хадгалан үлдээхэд чухал шаардлагатай байдаг.

Зүйл 17. Хадгалалт

Оршин байгаа бүтэц эсвэл түүний нөхцөл байдал соёлын

хэрэгсэл болон ашиглах бөгөөд ирээдүйн хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагаанд садаа болох ёсгүй.

Дурсгалт газрыг засвар үйлчилгээ нь уугуул иргэд болон бусад соёлын бүлгийн уламжлалт хууль журам, зан заншлыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой байж болно.

Дурсгалын бүтцийн баригдсан байдал

ач холбогдлын нотолгооноос бүрдэж байгаа бол, эсвэл бусад хадгалалт хамгаалалтын үйл явцыг хэрэгжүүлэх хангалттай нотолгоо байхгүй тохиолдолд урьдчилсан хадгалалт хамгаалалтын үйл ажиллагааг явуулна.

Зүйл 18. Сэргээн засварлалт ба сэргээн босголт

Сэргээн засварлалт болон сэргээн босголт нь тухайн газрын соёлын ач холбогдолтой талыг илтгэх ёстой.

Зүйл 19. Сэргээн засварлалт

Тухайн бүтцийн анхны төлөв, байдлын талаарх хангалттай баримт байгаа тохиолдолд сэргээн засварлалтыг хийхэд тохиромжтой.

Зүйл 20. Сэргээн босголт

20.1 Эвдрэл болон хувирал өөрчлөлтөөс үүдэлтэйгээр бүрэн бүтэн байдлаа алдсан тохиолдолд, тухайн бүтцийн анхны төлөв байдлыг харуулсан хангалттай баримт байгаа тохиолдолд сэргээн босголтыг хийх нь зохимжтой. Зарим тохиолдолд сэргээн босголтыг тухайн газрын соёлын ач холбогдлыг хадгалж буй дадал болон хэрэглээний нэг хэсэг болгон ашиглах нь зохимжтой байж болно.

20.2 Сэргээн босголт нь нарийвчилсан ашиглалт болон нэмэлт тайлбараар танигдахуйц байна.

болон ашиглалтыг харуулсан нотолгоо арилахгүйгээр хадгалахыг урьдчилсан хадгалалт гэнэ. Явц нь дараах дарааллаар явагдах ёстой.

- Ач холбогдлыг илэрхийлсэн бүтцийн нотолгоо хувирч өөрчлөгдөөгүй байх, эсвэл
 - 26-28 дугаар зүйлийн дагуу бодлогын шийдвэр гаргахыг зөвшөөрөх хангалттай судалгаа хийгдээгүй тохиолдолд
- Шинэ ажиллагаа (тогтворжуулах г.м) –г бүтцийн бодит шинж чанарыг хамгаалахаар 22 дугаар зүйлтэй уялдуулан, урьдчилан хадгалж, хамгаалах зорилгоор хийж болох юм.

Нийгмийн болон оюун санааны үнэт зүйлс бүхий дурсгалт газраас өчүүхэн жижиг хэсэг (барилгын суурь, туймэр, үер, шуурганаас үлдсэн модны хожуул) үлдэж хоцорсон ч сэргээн босгох үндэслэлтэй юм. Эрт үеийн төрх байдлыг дахин бүтээхийн тулд хангалттай хэмжээний баталгаа, нотолгоо ашиглахыг шаарддаг.

Зүйл 21. Шинэчлэн өөрчлөх

21.1 Шинэчлэн өөрчлөх гэдэг нь дурсгалын соёлын ач холбогдолд хамгийн бага нөлөө үзүүлсэн тохиолдолд хийгдэж болно.

21.2 Хэд хэдэн хувилбарыг авч үзэсний дараа дурсгалын бүтцэд хамгийн бага өөрчлөлт хийхийг шинэчлэн өөрчлөхөд хамааруулна.

Зүйл 22. Шинэ ажиллагаа

22.1 Тухайн дурсгалын соёлын ач холбогдлыг хүндэтгэсэн, ямар нэг байдлаар гажуудуулж, гуйвуулаагүй, эсвэл түүний тайлбар болон ойлголтыг сулруулаагүй тохиолдолд шинэ ажиллагааг, тухайлбал нөхөөс эсвэл бусад өөрчлөлтийг тухайн дурсгалд хийхийг хүлээн зөвшөөрнө.

22.2 Шинэ ажиллагаа нь нүдээр харахад мэдэгдэхүйц, дурсгалын соёлын ач холбогдлыг хүндэтгэсэн, хамгийн бага нөлөө үзүүлэхүйц байна.

Зүйл 23. Хадгалах эсвэл хэрэглээнд дахин нэвтрүүлэх

Ач холбогдолтой ашиглалтыг хадгалах, сайжруулах эсвэл дахин нэвтрүүлэх нь хадгалалт хамгаалалтын зохистой болон давуу хэлбэрүүд байж болох юм.

Шинэчлэн өөрчлөх гэдэгт: Дурсгалд нэмэлт хийх, шинэ үйлчилгээ эсвэл шинэ хэрэглээ эсвэл хадгалж хамгаалах зориулалтаар өөрчлөх зэргийг хамааруулна. Дурсгалт газрын шинэ ашиглалтад дасан зохицохыг "дасан зохицох шинэ ашиглалт" гэж тодорхойлдог бөгөөд 7.2 дугаар заалттай уялдаатай байх ёстой.

Дурсгалт газрын ач холбогдол, түүний байршил, эзэлхүүн, хэлбэр, хэмжээ, шинж чанар, өнгө, бүтэц болон материалыг харгалзаж шинэ ажиллагаа хийх ёстой. Дуурмалгаж хийхээс зайлхийх хэрэгтэй.

Шинэ ажиллагааг 3, 5, 8, 15, 21 болон 22.1 дүгээр заалттай уялдуулан хийх шаардлагатай.

Ач холбогдол бүхий бүтцэд өөрчлөлт хийхийг шаардаж болох ч хамгийн бага хэмжээнд тухайн өөрчлөлтийг хийх ёстой.

Зүйл 24. Холбоо хамаарал болон утга учрыг авч үлдэх нь

24.1 Хүмүүс болон дурсгалт газар хоорондын холбоо хамаарлыг хүндэтгэх, бууруулахгүйгээр авч үлдэх ёстой. Эдгээр холбоо хамаарлыг тайлбарлах, дурсах болон тэмдэглэх боломжийг судалж, хэрэгжүүлэх хэрэгтэй юм.

24.2 Тухайн газрын чухал утга, түүний дотор оюуны үнэт зүйлсэд хүндэтгэлтэй хандах ёстой. Эдгээр утгыг үргэлжлүүлэх буюу сэргээх боломжийг судалж, хэрэгжүүлэх хэрэгтэй.

Зүйл 25. Тайлбарлах

Маш олон газрын соёлын ач холбогдол нүдэнд илэрхий биш байдаг бөгөөд үүнийг тайлбарлах хэрэгтэй юм. Тайлбар нь ойлголт, оролцоог сайжруулахаас гадна тухайн соёлд нийцсэн байх ёстой.

ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ТУРШЛАГА

Зүйл 26. Буррагийн Хартиг хэрэглээнд нэвтрүүлэх нь

26.1 Дурсгалт газар дээр ажиллаж эхлэхээс өмнө зохих мэдлэг, чадвар болон зарчимд тулгуурлан түүний физик, баримтат, аман болон бусад нотолгоонд дүн шинжилгээ хийж судалсан байх хэрэгтэй юм.

26.2 Тухайн газрын соёлын ач холбогдлын талаар бичигдсэн мэдээлэл болон дурсгалт газрын талаарх бодлогыг бэлтгэж,

Зарим тохиолдолд ач холбогдолтой ашиглалт, үйл ажиллагаа, дадал зуршлыг үргэлжлүүлэхэд шинэ ажиллагааг хамруулж болох юм.

Зарим тохиолдолд тайлбарын аливаа хэлбэр нь соёлын хувьд тохиромжгүй байдаг.

Судалгааны үр дүнг цаг тухайд нь шинэчилж, шаардлагатай тохиолдолд нягталж, засварлаж байх ёстой.

Бодлого нь холбогдолтой бүхий л асуудлыг шийдвэрлэх ёстой. Жишээ нь: ашиглах, тайлбарлах, удирдах, өөрчлөх гэх мэт.

үндэслэлтэй, нотлох баримт болгон хавсаргасан байх ёстой. Ач холбогдлын талаарх мэдэгдэл, бодлогын тайланг тухайн газрын менежментийн төлөвлөгөөнд тусгах шаардлагатай юм.

26.3 Дурсгалт газар дээр ажиллаж эхлэхээс өмнө зохих мэдлэг, чадвар болон зарчимд тулгуурлан түүний физик, баримтат, аман болон бусад нотолгоонд дүн шинжилгээ хийж судалсан байх хэрэгтэй юм.

26.4 Тухайн газрын соёлын ач холбогдлын талаар бичигдсэн мэдэгдэл болон дурсгалт газрын талаарх бодлогыг бэлтгэж, үндэслэлтэй, нотлох баримт болгон хавсаргасан байх ёстой. Ач холбогдлын талаарх мэдэгдэл, бодлогын тайланг тухайн газрын менежментийн төлөвлөгөөнд тусгах шаардлагатай юм.

Зүйл 27. Өөрчлөлтийг удирдах

27.1 Санал болгож буй өөрчлөлт, үнд нэмэгдсэн өөрчлөлт тухайн газрын соёлын ач холбогдолд хэрхэн нөлөөлж байгааг ач холбогдлын талаарх мэдэгдэл, дурсгалт газрыг удирдаж буй бодлогод үндэслэн үнэлэх хэрэгтэй. Соёлын ач холбогдлыг илүү

Буррагийн Хартийн бүртгэлд тохиромжтой баримт бичиг бол Менежментийн төлөвлөгөө юм. Жишээ нь: Соёлын ач холбогдолтой газруудыг төлөвлөх, удирдах алхмуудыг тодорхойлсон байдаг. (6.1 дүгээр заалт болон хүснэгт). Ийм төлөвлөгөөг ихэнхдээ Хадгалалт хамгаалалтын менежментийн төлөвлөгөө гэж нэрлэх ба зарим тохиолдолд өөрөөр нэрлэдэг.

Менежментийн төлөвлөгөө нь тухайн газрын менежментийн холбогдолтой бусад асуудлыг мөн шийдвэрлэж болно.

Төлөвлөөгүй үр дүн гарах тохиолдолд байх тул авсан үйл ажиллагаанд хяналт тавих.

сайн хадгалж үлдээхийн тулд санал болгож буй өөрчлөлтийг сайжруулах шаардлагатай байж болно.

27.2 Дурсгалд аливаа өөрчлөлтийг хийхийн өмнө болон дараа оршин байгаа бүтэц, хэрэглээ, холбоо хамаарал, утга учрыг хангалттай хэмжээнд баримтжуулах ёстой.

Зүйл 28. Бүтцийн эвдрэл

28.1 Судалгаа болон нотолгоог олж авахдаа дурсгалд аль болох бага хэмжээний эвдрэл үзүүлэх. Зөвхөн тухайн дурсгалыг хадгалж хамгаалах шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах, алдагдсан болон нэвтрэх боломжгүй нотолгоог олж авах зорилгоор дурсгалын бүтцэд аливаа эвдрэл үзүүлэх судалгаа (тухайлбал археологийн малтлага)-г хийнэ.

28.2 Шийдвэр гаргах, дурсгалын бүтцийг эвдрэлд оруулж буй шалтгааныг тодруулахад шинжилгээ, судалгаа шаардлагатай бөгөөд энэ нь дурсгалт газарт явуулж буй бодлоготой уялдаатай байх нь зохистой. Энэ төрлийн шинжилгээ судалгаа нь мэдлэгийг нэмэгдүүлж чадахуйц судалгааны асуултад тулгуурласан, бусад аргаар хариулах боломжгүй байх ба бүтцийн эвдрэлийг бууруулах ёстой.

Зүйл 29. Хариуцлага

Удирдлага шийдвэрийг хариуцах байгууллага, хувь хүмүүсийг нэрлэж, шийдвэр тус бүрт тодорхой хариуцлага хүлээлгэх ёстой.

Зүйл 30. Чиглэл, зөвлөмж болон хэрэгжүүлэлт

Хадгалалт хамгаалалтын бүхий л шатанд чадварлаг удирдаж, хяналтыг бүх шатанд хадгалж, аливаа өөрчлөлтийг зохих мэдлэг, ур чадвартай хүмүүсээр гүйцэтгүүлж байх ёстой.

Зүйл 31. Бүртгэл хөтлөх

Дурсгалт газрыг хамгаалах бодлого эсвэл төлөвлөгөөг хэрэгжүүлж байхад шинэ баримт нотолгоо олдож болох юм. Бусад хүчин зүйлс гарч ирж магадгүй бөгөөд шинэ шийдвэр гаргах шаардлагатай болно. Шинэ нотлох баримт, нэмэлт шийдвэрийн тэмдэглэл хөтлөх ёстой.

Зүйл 32. Тэмдэглэл

32.1 Дурсгалын хадгалалт хамгаалалтын холбогдолтой тэмдэглэлийн аюулгүй байдал, нууцлалын шаардлагыг харгалзан байнгын архивд хадгалах байдлаар олон нийтэд нээлттэй байлгах хэрэгтэй.

32.2 Тухайн газрын түүхийн тухай тэмдэглэлийг аюулгүй байдал нууцлалын шаардлага, соёлын хувьд тохиромжтой тохиолдол хамгаалж, олон нийтэд мэдээлэл ёстой.

Зүйл 33. Нүүлгэн шилжүүлсэн бүтэц

Дурсгалаас нүүлгэн шилжүүлсэн ач холбогдолтой бүрдэл

Шинэ шийдвэр нь тухайн газрын соёлын ач холбогдлыг хүндэтгэсэн, хамгийн бага нөлөө үзүүлэхүйц байх ёстой.

хэсэг, тухайлбал эд зүйлс, тоног төхөөрөмж зэргийг соёлын ач холбогдлынх нь дагуу каталогжуулан хадгалах ёстой.

Дурсгалаас нүүлгэн шилжүүлсэн эд зүйлс, тоног төхөөрөмжийг дурсгалт газарт нь соёлын хувьд зохистойгоор хадгалах хэрэгтэй.

Зүйл 34. Нөөц

Хадгалалт хамгаалалтад хангалттай нөөцөөр хангах ёстой.


Хамгийн сайн хадгалалт хамгаалалт ихэвчлэн хамгийн бага ажиллагаа, зардлаар хийгддэг.

Буррагийн Хартийг хэрэгжүүлэх “Явц”-ын бүдүүвч.

Соёлын дурсгалт газрыг удирдах болон төлөвлөх алхмууд.

Буррагийн Хартийг бүхэлд нь унших хэрэгтэй.

Алхам бүрд холбогдолтой гол заалтуудыг графикт харуулав. Буррагийн Хартийг хэрэгжүүлэх явцыг заалт 6-д хураангуйлав.



Товчилсон үгийн жагсаалт

UNESCO	Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
ICOM	Олон Улсын Музейн Зөвлөл
ICROM	Соёлын өвийг хадгалах, сэргээн засварлах ажлын судалгааны төв
ICOMOS	Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хамгаалах Олон улсын зөвлөл
Venice charter	Венецийн Харти (Хөшөө дурсгал, дурсгалт газруудыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах тухай Олон улсын Харти)
Burra Charter	Буррагийн Харти /2013 оны Австралийн ICOMOS-ийн Соёлын ач холбогдол бүхий дурсгалт газрын Харти /